



НЬЮ СЕМЕТРИ
ОРШООХ ҮЙЛЧИЛГЭЭ

БАТЛАВ.

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА



ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН:

“НЬЮ СЕМЕТРИ” ХХК-ийн ДЭД ЗАХИРАЛ



/Ж.БУМТУШИГ/

**“НЬЮ СЕМЕТРИ” ХХК-ийн ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ, БАЯН-УУЛЫН ЭНГЭР
ДЭХ “ДИВААЖИНГИЙН ЦЭЦЭРЛЭГТ
ХҮРЭЭЛЭН” НЭРТЭЙ ДАЛД ОРШУУЛГЫН
ГАЗРЫН**

**2019 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хянасан: Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн:


Боловсруулсан:

“Нью Семетри” ХХК-ийн Стандарт хариуцсан менежер

/Р.ОЮУНГЭРЭЛ



НЬЮ СЕМЕТРИ
ОРШООХ ҮЙЛЧИЛГЭЭ

БАТЛАВ. БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга  /П.Цогтсайхан/


ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН
"Нью Семетри" ХХК-ийн Гүйцэтгэх захирал  /М.Мөнхзаяа/




"НЬЮ СЕМЕТРИ" ХХК-ийн ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ, БАЯН-УУЛЫН ЭНГЭР ДЭХ "ДИВААЖИНГИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН" НЭРТЭЙ ДАЛД ОРШУУЛГЫН ГАЗРЫН

2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ААНэгжийн регистрийн дугаар: **5065437**

Хянасан: БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын мэргэжилтэн:  /М.Тулга/

Боловсруулсан:

"Нью Семетри" ХХК-ийн Үйл ажиллагааны захирал  /Ж.БУМТУШИГ/

"Нью Семетри" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн  /Р.ОЮУНГЭРЭЛ/



НЬЮ СЕМЕТРИ
ОРШООХ ҮЙЛЧИЛГЭЭ

БАТЛАВ. БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын

газрын дарга _____ / _____ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“Нью Семетри” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

_____ /М.Мөнхзаяа/

**“НЬЮ СЕМЕТРИ” ХХК-ийн ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН
СУМЫН НУТАГ, БАЯН-УУЛЫН ЭНГЭР ДЭХ
“ДИВААЖИНГИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН” НЭРТЭЙ
ДАЛД ОРШУУЛГЫН ГАЗРЫН
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ААНэгжийн регистрийн дугаар: **5065437**

Хянасан: БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын мэргэжилтэн :

_____ / _____ /

Боловсруулсан:

“Нью Семетри” ХХК-ийн Стандартын менежер _____ /Д.Доломжав /

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Төслийн товч танилцуулга.....	2
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн загсийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	5
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	5
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	5
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	5
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	5-6
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	8-9
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	7
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Нью-Семетри” ХХК нь 2006 онд анх үүсэн байгуулагдсан бөгөөд байгуулагдсан цагаасаа хойш оршуулгын үйлчилгээг олон улсын жишигт хүргэх, шинэ дэвшилтэт технологийг өөрийн орны уламжлалт зан үйлтэй хослуулан далд оршуулгын буяны үйлчилгээг иргэдэд нэн хүндэтгэлтэй, цогц байдлаар үзүүлж ирсэн.

Одоогоор “Нью-Семетри” ХХК нь 3 газар, 128 ажиллагсадтайгаар Улаанбаатар хотын баруун зүгт Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо “Шүлэг уул”-ын энгэрт “ДУРСГАЛЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН “–г мөн Улаанбаатар хотын зүүн зүгт Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р баг “Баян уул”-ын энгэрт “ДИВААЖИНГИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН” бүхий далд оршуулгын газруудад үйл ажиллагаагаа явуулж байна.

Бидний үзүүлж буй буяны цогц үйлчилгээнд:

- ✓ Том суваргатай багцын үйлчилгээ
- ✓ Жижиг суваргатай багцын үйлчилгээ
- ✓ Хөшөөтэй багцын үйлчилгээ
- ✓ Бунханы багцын үйлчилгээ
- ✓ Чандарын хананы багц үйлчилгээ гэсэн 5-н төрлийн багцын үйлчилгээнээс сонголт хийх боломжтой бөгөөд дээрхи багц үйлчилгээнд:

1. Хайрцаг сонголтоор / Дотоодын эсгий лакан, гадаадаас оруулж ирдэг Америк стандартын хайрцагнаас сонголтоо хийх/
2. Шашны зан үйл /газар авах болон ёслолын өдөр газар дээрх зан үйл хийх ламын үйлчилгээ/
3. Бурхан болоочийг тээвэрлэх машины үйлчилгээ
4. Хүндэтгэлийн мандлын амьд цэцэгийн үйлчилгээ
 - ✓ 108 зулын үйлчилгээ
 - ✓ Бие ороох өнгө дагуу ноосон хөнжил
 - ✓ Гар рашаалах үйлчилгээ
 - ✓ Бэлтгэл ажил /Хөшөөний бичилт, суурилуулалт болон бусад/
 - ✓ Байнгын харуул хамгаалалт бүхий цэвэр орчин
 - ✓ Цаашдын зүлэгжүүлэлт цэцэрлэгжүүлэлт, тохижилт зэрэг үйлчилгээ багтдаг.

Диваажингийн цэцэрлэгт хүрээлэнд 2014 онд шинээр хүндэтгэлийн өргөө, Олон улсын стандарт, технологийн дагуу хийгдсэн бунхан, Төв асар хаалга, Зулын өргөө болон гар рашаалах байр, засмал зам, зогсоол, гэрэлтүүлэг зэрэг бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээр танхим дахь ёслол хүндэтгэлийн үйлчилгээ багц үйлчилгээнд нэмэгдэж орсон бол Диваажингийн цэцэрлэгт хүрээлэнгийн багцын үйлчилгээнд 2015 оны 1 сараас цагааллагын багц үйлчилгээг тус тус нэмж оруулсан мөн 2015 оны 12 дугаар сараас эхлэн Нийслэлийн хэмжээний зөвшөөрөл бүхий оршуулгын газруудад мөн оршуулгын үйлчилгээг цогц байдлаар илүү хямд үнэтэй үйлчилгээг бий болгон нэвтрүүлэн ажиллаж байгаа зэрэг нь иргэдэд хүрч, сэтгэлд нийцсэн үйлчилгээ болохын зэрэгцээ талийгаачдын ар гэрийхэнд учирсан уй гашууг хуваалцан, буяны үйлчилгээг чанартай, түргэн шуурхай, цогц байдлаар үзүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үйлчилгээгээ улам илүү сайжруулах хүрээнд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, OHSAS18001:2007 ХАБЭА-н менежментийн тогтолцоог байгууллагын үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа юм.

Манай хамт олон нь оршуулгын дэлхийн стандартад нийцсэн үйлчилгээг хүргэх зорилгоор ICCFA /Олон улсын оршуулгын холбоо/, NFDA /Үндэсний оршуулгы үйлчилгээний захиралуудын холбоо/, ACCA /Ази Австралийн оршуулгын холбоо/, FIAT-FIFTA /Хятадын оршуулгын холбоо/ гэх мэт

дэлхийн оршуулгын холбоодуудад нэгдэн орж, тэдгээр байгууллагуудаас туршлага судлан, Олон улсын болон бүс нутгийн урт болон богино хугацааны мэргэжлийн сургалтанд ажилчдаа сурган дадлагажуулж ур чадвартай, ёс суртахуун болон сэтгэл санааны хувьд бэлтгэгдсэн баг хамт олоноор буяны үйлчилгээг үзүүлсээр байна.

Бидний үзүүлж буй үйлчилгээнд:

<p><i>Том суваргатай багцын үйлчилгээ</i></p> 	<p><i>Жижиг суваргатай үйлчилгээ</i></p> 
<p><i>Хөшөөтэй багцын үйлчилгээ</i></p> 	<p><i>Бунханы багцын үйлчилгээ</i></p> 
<p><i>Чандарын хананы багцын үйлчилгээ</i></p> 	<p><i>Эко үйлчилгээ</i></p> 

Энэхүү 6-н төрлийн багцын үйлчилгээнээс сонголт хийх боломжтой бөгөөд дээрх багц үйлчилгээнд:

1. Хайрцаг сонголтоор (Дотоодын эсгий лакан хайрцаг, импортын Америк стандартын хайрцагнаас сонголт хийх)




2. Шашны зан үйл (газар авах болон ёслолын өдөр газар дээрх зан үйл хийх ламын үйлчилгээ)



3. Бурхан болоочийг тээвэрлэх тусгай зориулалтын автомашины үйлчилгээ





Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн




Диваажингийн цэцэрлэгт хүрээлэн



ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжиж буй талбай нь Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт Налайх дүүргийн нутагтай хил залгаа буюу Баян-Уулын энгэрт, Хоолтийн хөндийд оршино.



Зураг 1. Диваажингийн цэцэрлэгт хүрээлэнгийн байршил

№	Өргөрөг	Уртраг
1	47.71139889	107.2122528
2	47.71700806	107.2086297
3	47.71687833	107.2196286
4	47.71053556	107.2174047

НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ



Төв аймгийн Сэргэлэн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Дархан гүний хошуу. Баян бүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 5 багийн нийт 716 өрхөд 1841 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас 17-д, газар нутгийн хэмжээгээр эхний 5-д ордог.

Газар нутгийн хэмжээ, байрлал:

Төв аймгийн зүүн урд хэсэгт: Улаанбаатар хотоос 62 км, аймгийн төвөөс 18 км зайд байрладаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Алтанбулаг, Эрдэнэ, Баян, Баянцагаан сумтай хиллэдэг. Нийт газар нутгийн хэмжээ 27132.46 га.

Хүснэгт 1. Газар ашиглалтын хэлбэр

Зориулалт	Хэмжээ (га)	Нийт талбайд эзлэх
		хувь
Хөдөө аж ахуйн газар	36446,75	91.8
Ойн сан бүхий газар	4975,80	1.27
Усан сан бүхий газар	309	0.08
Тусгай хэрэгцээний газар	18201.8	4.71
Тосгон, суурингийн газар	5172.76	1.25
Дэд бүтцийн газар	3448.9	0.89
Нийт	27132.46	100

Хүн ам:

Тус сум нь Төв аймагтай хаяа нийлэн оршдог нийт хүн амын 46 хувь нь сумын төвд амьдардаг. Сумын хүн амын 60 хувь нь залуу болон дунд насныхан, 25 хувь нь хүүхэд, 15 хувь нь хөгшид байна.

Хүснэгт 2.. Хүн амын мэдээлэл

№	Үзүүлэлт	Сумын төв	Хөдөө	Нийт
1	Хүн амын тоо	780	1121	1841
2	Өрхийн тоо	197	519	716
3	Суурин хүн ам	-	-	1841
4	Түр оршин суугч	-	-	0.0

Нийгэм-эдийн засаг:

Сумын хэмжээнд нийт 56 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 10,1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 150,3 сая, орон нутагт 80,9 сая нийт 2090.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

Тус суманд тусгай зөвшөөрөл эзэмшдэг 17 аж ахуй нэгж байгууллага жилд 100 килограмм алт олборлож 8,2 тэр бум төгрөгийн татварыг төвлөрүүлдэг юм. Тус суманд улсын хэмжээний томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь орон нутгийн болоод улс орны эдийн засаг хөгжилд ихээхэн нөлөө үзүүлхүйц байгууламжууд хийгдэж байна. Үүнд: 50квт Салхин цахилгаан

станд 2013 онд ашиглалтанд орон үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Мөн Олон Улсын нисэх онгоцны буудал 2017-2018 онд ашиглалтанд орохоор ажиллаж байна

Жилд 100 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий цементийн үйлдвэр мөн хийт бетон үйлдвэрүүд 2015 онд ашиглалтанд орж улсынхаа нүүр царай болсон төслүүд хэрэгжиж байна.

Мал аж ахуй, газар тариалан:

Сумын хэмжээгээр нийт 140,9 мянган мал тоологдсоноос тэмээ 32 буюу 0,02% ямаа 43159, буюу 30,60% хонь 69193, 49,0% үхэр 8574 буюу 6,08% адуу 19972, буюу 14,17% тус тус тоологдсон байна. 266 малчин өрх, 69 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 46,6 хувийг эзэлж байна.

Сумын хэмжээгээр жилд 222 га-д тэжээлийн ургамал, 160 га талбайд үр тариа, 44,2 га талбайд төмс, 18,36 га талбайд хүнсний ногоо, тэжээлийн ургамал 240 тн, 400 тонн төмс, 40 гаруй тонн хүнсний ногоо, хураан авахаар бэлтгэл ажил хангагдаад байна.

Боловсрол:

Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 8 бүлэгт өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 22 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 23,2 хувь, суурь боловсролын хамран сургалт 19,6 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100% хувьтай байгаа ба мэргэжил дээшлүүлэх хөрвөх сургалтанд нийт 9 багш хамрагдаж байна. Төрийн өмчийн “Алтан түлхүүр” цэцэрлэгийн үндсэн сургалтанд 120 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамралт 94,0 хувьд хүрсэн.

Эрүүл мэнд:

Суманд улсын төсвийн 7 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 2 их эмч, 12 эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна. 2019 онд нийт 16 хүүхэд мэндэлж, 0-1 насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл байхгүй байна. Нийт өвчлөлийг авч үзвэл халдварт бус өвчлөл 125, осол гэмтэл 10, халдварт өвчлөлийн 10 тохиолдол гарсан байна.

Соёл, спорт:

1979 онд ашиглалтанд орсон 120 суудалтай Соёлын төвийн тоосгон барилга нь зориулалтын бус. Тус барилгад урлагийн тоглолт, дугуйлан, номын сангийн үйлчилгээ зэрэг бүх соёл урлагийн үйл ажиллагаа явагддаг, спорт зааланд спортын арга хэмжээ зохион байгуулж байна.

Ажилгүйдэл, ядуурал:

Суманд бүртгэлтэй ажилгүй иргэд 14 байна. Нийт ажилгүй иргэдийн 0,8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 10 хувийг дээд, 4 хувийг тусгай дунд, 50 хувийг бүрэн дунд, 16 хувийг бүрэн бус дунд, 6 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

Инженерийн дэд бүтэц:

Зам тээвэр-Сумын газар нутаг Улаанбаатар төмөр зам дайран өнгөрдөг бөгөөд төмөр замын 5-н өртөө, зөрлөг байрладаг. Зүүн талаараа УБ, Чойр, босоо тэнхлэгийн хатуу хучлагатай замтай, баруун хэсгээр УБ, Мандалговийн хатуу хучлагатай зам тус тус дайран өнгөрсөн, багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Цахилгаан хангамж-Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1969 онд баригдсан 110/35/10квт-ийн Дэд станцтай.

Ус хангамж-Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 5 гүний худаг, 30м3 багтаамжтай ус хангамжийн системд 5 аж ахуйн нэгж холбогдож бусад айл өрх ус түгээх байрнаас усаа авч байна.

Дулаан хангамж-Сумын төвд 3-н байгууллага төвлөрсөн цахилгаанаар халдаг. Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулиудын харьяа бага оврын уурын зуухнууд ажиллаж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нью Семетри ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Баян-Уулын энгэр дэхь “Диваажингийн цэцэрлэгт хүрээлэн” бүхий далд оршуулгын газрын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж нөлөөллийн нэмэлт тодотголын суурь судалгааг үндэслэлээ.

- Агаар орчныг бохирдуулагч томоохон эх үүсвэр байхгүй,
- Ургамалан нөмрөгийн хувьд нэмэлт нөлөөлөл харьцангуй бага бөгөөд ногоон байгууламжийг зарим хэсгүүдэд шинээр бий болгох шаардлагатай юм.
- Хөрсний эвдрэл, бохирдлыг хамгийн бага байх зарим арга хэмжээнүүдийг төсөл хэрэгжүүлэгч төлөвлөж ажиллах шаардлагатай. Мөн шарилны ялзрал болон задрах үйл явцаас хөрсөнд болон гүний усанд элдэв хорт бодис ялгарах магадлалтай учир нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай байна.
- Төсөл хэрэгжиж буй талбайд гадаргын ус байхгүй бөгөөд гүний худгийн усаар бүх усны хэрэгцээг хангаж байна. Иймд усны хэрэглээг хамгийн бага байх бүхий л арга хэмжээг авч ашиглах, ногоон байгууламж, зүлэг зэргийн усалгаанд саарал усыг ашиглах боломжийг эрэлхийлэх шаардлагатай юм.
- Амьтны аймгийн хувьд цөөн зүйлийн түгээмэл статустай шувууд тохиолдох бөгөөд төслийн зүгээс ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.
- Түүх соёлын өвийг агуулсан олдвор одоогийн байдлаар илрээгүй байгаа хэдий ч төслийн үйл ажиллагаагаар бий болж буй бурхан шүтээний барилга байгууламжууд нь орчин үеийн түүх соёлын шинж чанартай болж байна. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн дагуу хамгаалах шаардлага бий болж байна.

Энэхүү төсөл нь бүс нутгийн байгаль орчин, болон нийгмийн эрүүл мэнд, орчны эрүүл ахуйг сайжруулж буй эерэг төсөл болох нь энэхүү тайлангаас харагдаж байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОННУ) үр дүнд үндэслэн үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээг арилгах, бууруулах ажлыг төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зүй, хөрөнгө зардлын тооцоо, хариуцах нэгж зэргийг нэг бүрчлэн зааж өгөх, үйл ажиллагаанд баримтлах хууль эрх зүй, стандартуудыг тодруулж өгөх нь энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний зорилго оршино.

БОМТ-г боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618

тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, болон холбогдох бусад хууль, журам, стандартыг мөрдлөг болгон боловсруулаа.

Төслийн үйл ажиллагааны жил 2023 оны хугацаанд гүйцэтгэх ажлын зардлыг дараах байдлаар төлөвлөсөн бөгөөд 165810000 төгрөгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд зарцуулах шаардлагатай юм.

Хүснэгт 1. Зардлын зарцуулалт

Хийх ажил	2023
Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал	105000000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	750000
Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлт	59200000
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд	560000
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг олон нийтэд тайлагнах ажлын зардал	300 000
Нийт	165810000

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны үед үүсэх гол сөрөг нөлөөллийг үнэлгээгээр тогтоосны дагуу арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв зэргийг тусгаж өгсөн.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Сул шороон зам тоосжилт үүсгэх	Замыг засмалжуулах	ДИЦХ	M2			75000000		
3.	Хөрсний эвдрэл, жалга гуу үүсгэх,	Үерийн далан хийх	ДИЦХ	M2			30000000		
4.									
5.									
	Нийт						105000000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ногоон байгууламж	Гацуур	Хөрсний үйлчилгээнд	ш	100	300,000	30,000,000	2-р улиралд	Байгаль хамгаалах тухай хууль
2.		Хайлаас	Шинэ үйлчилгээнд /50 айл/	ш	2500	2,000	5,000,000		
3.		Хайлаас	Лагшери үйлчилгээний эргэн тойронд	ш	12000	2,000	24,000,000		
	Нийт				14600		59.200.000		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн хайгуул судалгаагаар ямар нэгэн түүх соёлын олдвор илрээгүй юм. Цаашид барилга, байгууламжийн ажлын үед түүх соёлын өвийг агуулсан зүйлс олдвол “Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3” зүйл заалтын дагуу мэргэжлийн байгууллагад хандаж авран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч үл маргах замаар шийднэ. Иймд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгайлан зардал тусгаагүй болно.

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.		Хог хаягдлын гэрээг сунгуулах	ДИЦХ	ш	30000	12	360000	1	Хог хаягдлын тухай хууль
2.	Ахуйн	Хогын савыг сар бүр ариутгал хийх	ДИЦХ	ш	0	12	200000	Сар бүр	
2.	Үйлдвэрийн	-	-	-	-				
3.	Аюултай	-	-	-	-				
	Нийт						560000		

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	ДИЦХ гол талбай	1	1	150000	150000		MNS 5850:2019 /ЗДХ/
2.	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	ДИЦХ гүний худаг	1	1	150000	150000		MNS 0900:2018
3.	Ундны усны бүрэн шинжилгээ	ДИЦХ гүний худаг	1	1	150000	150000		MNS 0900:2018
4.	Ундны усан дахь хүнд металлын агууламж	ДИЦХ гүний худаг	1	1	150000	150000		MNS 0900:2018
5	Агаарын чанарын шинжилгээ	ДИЦХ	1	1	150000	150000		MNS 4585:2016
	Нийт					750000		

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
4.	БОМТайланг боловсруулж, тухайн жилийн 11 сарын 15-ны өмнө орон нутгийн БОГазарт танилцуулан баталгаажуулж байх	0			11	Стандартын менежер, Цогцолборын менежер	БОАЖЯ-ны сайдын А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу
5.	БОМТөлөвлөгөөг боловсруулж, тухайн жилийн 12 сарын 10-ны өмнө орон нутгийн БОГазарт танилцуулан баталгаажуулж байх	0			12	Стандартын менежер, Цогцолборын менежер	
6.	БОАЖЯ-нд БОМТайланг тайлагнана.				12	Стандартын менежер, Цогцолборын менежер	
	Нийт						

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Төв аймгийн Сэргэлэн сумын иргэдэд 2022 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг тайлагнах	Хурал зохион байгуулах	ДИЦХүрээлэнгийн үйл ажиллагаа нь байгаль орчинд нөлөөлж буй байдал	2023.11.15		Д.Сүхбаатар	Төв аймгийн Сэргэлэн сумын тамгын газарт

8.1 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь бараа материалын сав, баглаа болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилна. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болох хэдий ч төслийн байгууламж нь төвийн бохирын системд бүрэн холбогдсон учир нэмэлт шингэн хаягдал үүсэхгүй.

Төслийн үйл ажиллагааны хугацаанд 30 орчим хүн тогтмол ажиллахаар хаягдлын хэмжээг тооцсон бол барилгын гаралтай хог хаягдал үүсэхгүй. Ахуйн хог хаягдлыг жилд 10-12 удаа хогийн цэгт хүргүүлнэ. Хог хаягдлын төлөвлөгөөг дээр дурьдсан нэгдсэн төлөвлөгөөнд оруулсан.



Зураг 1. Хогийн савны төрөл

Хогийн саванд тавигдах шаардлага: (Хог хаягдлын тухай хууль)

- 15.1.1. хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- 15.1.2. галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- 15.1.3. хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

Хог хаягдал түүнийг цэвэрлэх, зайлуулах болон зохицуулах хэлбэр:

- Ангилсан хог хаягдлаас боломжтой хэсгийг хоёрдогч түүхий эдийн цэгүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тогтмол тушаана.
- Барааны сав, баглаа боодлыг зориулалтын хогийн саванд хийнэ. Ингэхдээ хууль, журмын дагуу энгийн, хяналттай, аюултай шинж чанараар нь ангилж хадгална. Үүний хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тушааж байна.

10.1 Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлагын тогтолцооны үе шат бүрд ямар арга хэмжээг хэрхэн төлөвлөх, яаж тодорхойлж хийж гүйцэтгэсэн байх шаардлагатайг дор нэг бүрчлэн оруулаа.

Байгаль орчны бодлого: Төслийн талбай, түүний орчмын байгаль орчны төлөв байдал, төслийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзсэн байгаль орчны бодлогыг боловсруулан хууль эрхзүйн болон бусад шаардлагыг тогтоож, түүнийг мөрдөх журам боловсруулан ажиллах.

Байгаль орчны төлөвлөлт: Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгэж, түүнийг бууруулах арга замыг тодорхойлон байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл болон эрсдэлийг бууруулах бодит зорилго, зорилтыг тодорхойлон жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд оруулах.

Байгаль орчны зорилго зорилгод хүрэх үүрэг хариуцлагын зохион байгуулалт, хүрэх арга зам, хугацаа, хэрэгжилтийн үе шатанд хүний нөөц, мэргэшсэн, ур чадвар бүхий боловсон хүчин, орчин үеийн дэвшилтэт технологи, санхүүгийн эх үүсвэрүүд зэрэг бүхий л асуудлыг төлөвлөх.

Хэрэгжүүлэлт, гүйцэтгэл: Байгаль орчны зорилго, зорилгод хүрэх төлөвлөгөөг хугацааны дагуу зохион байгуулагдсан бүх л арга хэмжээг цаг алдалгүй хууль эрхзүй орчин болон стандарт норм, бусад шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэх.

Хяналт шалгалт: Байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд байгаль орчны хууль эрх зүй, дүрэм журам, стандарт норм, бусад шаардлага болон төсөл хэрэгжихээс өмнөх байгаль орчны суурь нөхцөлтэй харьцуулалт хийж тогтмол хугацаанд хяналт шалгалт хийх.

Удирдлагын сайжруулалт: Байгаль орчны хяналт шалгалтын үр дүнд тулгуурлан төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага нь байгууллагынхаа байгаль орчны удирдлагын тогтолцооны нийцтэй, тохиромжтой, үр ашигтай байдлыг тогтмол хангахын тулд тогтоосон хугацаанд түүнд дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээний үр дүнгээс хамааруулан үйл ажиллагааг тогтмол сайжруулж, улмаар түүний нийцтэй байдлыг үнэлж, үл тохирох, засч залруулах арга хэмжээг авах талаар заасан журам боловсруулж нэвтрүүлнэ.

11.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах журмын дагуу төслийн нөлөөлөлд өртөх магадлалтай оршин суугчид, оролцогч талуудад байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж байх үүрэгтэй бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. Тайлагнах хуваарийг дээрх дурьдсан нэгдсэн төлөвлөгөөнд оруулав.